

БОЛГАР, УНГАР, ПОЛЫШ, ЧЕХ ОРНЫ ТАЛААР ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

*Д.Золбоо**

Манай хуралд оролцсон орнуудын талаар арай дэлгэрэнгүй мэдээлэл өгөх үүднээс “World Fact Book 2004” болон Дэлхийн худалдааны байгууллагын мэдээллийн сан болон Монгол Улсын Үндэсний Статистикийн газрын мэдээлэл зэрэг номноос товчлон авч хүргэж байна. Дэлгэрүүлэн үзэхийг хүсвэл www.two.org, www.cia.gov/cia/publications/factbook хуудас болон тухайн орны холбогдох бусад эх сурвалжаас нягтлан үзэхийг хүсье.

БОЛГАР

Болгарчуудыг Төв Азийн Түрэг гаралтай нүүдэлчин овог аймаг, нутгийн Слав гаралтай оршин суугчидтай уусан нэгдэж бүрэлдэн бий болсон гэж үздэг бөгөөд МЭ-ний VII зууны сүүлээр тэд анхны төрт улсаа байгуулж байсан түүхтэй ажээ. Хүчирхэгжин мандаж байхдаа хэдэн зууны турш эртний хүчирхэг Византын эзэнт гүрэнтэй Балканы хойг дахь газар нутгаа хамгаалан амжилттай тэмцэж байсан хэдий ч XIY зууны сүүлээр Оттоман Түрэгийн захиргаанд орж байжээ. Хойд Болгарчууд 1878 оны 3 сарын 2-нд автономит эрх олж авсан бол 1908 оны 9 сарын 22-нд Болгар нь бүрэн тусгаар тогтносон улс болжээ. Тиймээс болгарчууд 3 сарын 3-ныг Чөлөөлөгдсөний баярын өдөр болгон тэмдэглэдэг ажээ. Дэлхийн 2 том дайнд хоёуланд нь ялагдсан талын бүрэлдхүүнд орж явсан бөгөөд 1946 онд Бүгд Найрамдах Болгар Улсыг тунхаглан Зөвлөлтийн бүлэглэлд албан ёсоор нэгдэн оржээ. 1990 онд Коммунист засаглал задран унаснаар, дэлхийн II дайнаас хойш анхны олон намын сонгууль болж энэ бүх хугацаанд өмнө нь социалист замналаар явсан бусад улс орны нэгэн адил ажилгүйдэл, мөнгөний ханшны уналт, хээл хахууль, гэмт хэрэг зэрэг олон зүйлийн саад бэрхшээлийг даван туулж улс төрийн ардчилал, чөлөөт зах зээлийн эдийн засгийн шинэчлэлийг тууштай хэрэгжүүлж байна. Өнөөдөр Болгар орон Европын холбоонд нэгдэхийн төлөө өөрчлөлт шинэчлэлт, ардчиллыг эрчимтэйгээр сэргээн байгуулж буй бөгөөд 2004 онд Умард Атлантын Цэргийн Эвсэлд (НАТО) нэгдсэн билээ.

Газар зүйн байршил: Европ тивийн Зүүн өмнөд хэсэгт Хар тэнгисийн эрэгт Румын, Грек, Туркын дунд оршино. Нийт 110.910 км хавтгай дөрвөлжин нутаг дэвсгэртэйгээс 360 км нь ус эзэлнэ. Гректэй 494 км, Македонтой 148 км, Румынтай 608 км, Серб ба Монтенегротой

*Д.Золбоо - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

318 км, Турктэй 240 км газраар хиллэдэг ба 304 км урт усан хилтэй ажээ. Хамгийн өндөр цэг нь Мусала оргил 2.925 метр.

2004 оны 7 сарын байдлаар 7.517.973 хүн амтай, дундаж нас 40.5, дундаж наслалт 71.7 ажээ. Хүн амын өсөлт -0.92%, 2001 оны байдлаар ДОХ-той 346 хүн бүртгэгдсэнээс 100 нь нас барсан байна. Хүн амын 83.9 % нь болгар, 9.4% нь турк, 4.7% нь рома болон бусад үндэсний цөөнх болох македон, армен, татар, циркасууд 2%-ийг эзэлдэг ажээ. Үүнийгээ дагаад шашин шүтлэгийн хувьд 82.6 хувь нь болгарын ортодокс, 12.2% нь муслим шашинтнууд байдаг бол бусад нь жүүд, протестант, григорийн армен болон бусад шашин шүтдэг ажээ.

Албан ёсны хэл нь болгар хэл. Нийслэл нь Софи хот. Засаглалын хувьд парламентын ардчилалтай, засаг захиргааны нэгж нь 28 хэсэгт хуваагддаг. 1991 оны 7 сарын 12-нд шинэ Үндсэн хуулиа батлан мөрдөж эхэлжээ.

Эдийн засгийн хувьд Европын холбоонд нэгдэхийн төлөө хичээл зүтгэл гаргаж буйн хувьд 1996 оноос эдийн засгийн өсөлт ажиглагдаж байгаа бөгөөд Засгийн газрын шинэчлэлийн бодлогын үр дүнд 2001 он гэхэд ОУВС-аас 300 сая ам.долларын тусламж үзүүлж ядуурал, ажилгүйдэлтэй тэмцэх тэмцэлдээ тодорхой хэмжээгээр амжилт олж буй ажээ. 2002 оны байдлаар хүн амын 13.4 хувь нь ядуу амьдарч байна гэсэн статистик тоо баримт байдаг ажээ. 2003 онд мөнгөний ханш уналт 2.3 хувьтай гарсан бол ажилгүйдлийн төвшин 14.3% байдаг байна. ХАА болон аж үйлдвэрийн бүтээгдэхүүн голлох бөгөөд үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлт 6.3% байна. Итали, Герман, Грек зэрэг орнуудад бэлэн хувцас, гутал, төмөр ган зэрэг бүтээгдэхүүн экспортолдог бөгөөд 2003 онд экспортын хэмжээ 7.3 тэрбум ам.долларт хүрсэн бол импорт 9.7 тэрбумд хүрчээ. Манай 2 орны худалдааны эргэлт 2003 онд 1.5 сая ам.долларт хүрсэн байна. Мөнгөний нэгж нь лев BGN, 1999 оны 7 сард мөнгөний шинэчлэл хийж хуучин 1000 левийг шинэ 1 левтэй тэнцүүлсэн бөгөөд 2003 оны байдлаар нэг доллар 1.7 левтэй тэнцдэг ажээ. 2002 оны байдлаар 630 мянган интернэт хэрэглэгчтэй байсан бөгөөд болгарын интернэт код нь .bg юм.

УНГАР

Дэлхийн нэгдүгээр дайнаар задарсан Австри-Унгарын хаант улсын бүрэлдхүүнд багтаж байсан энэ орон мөн дэлхийн хоёрдугаар дайны дараагаар коммунист засаглалд шилжжээ. 1956 онд Варшавын гэрээг эсэргүүцсэн мөргөлдөөн гарсны улмаас Москвагаас цэргийн цохилт амсч байв. 1968 оноос Янош Кадарын удирдлаган дор Унгарт эдийн засгийн либералчлал, шинэчлэл хийгдэж эхэлсэн нь “Гулаш коммунизм” гэж нэрлэгдэж байжээ. 1990 онд анхны олон намын

тогтолцоотой улс төрийн сонгууль явагдсан бөгөөд чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлсэн байна. 1999 онд НАТО, 2004 онд Европын Холбоонд гишүүнээр элсчээ.

Газар зүйн байрлал. Төв Европт Румыний баруун хойно орших энэ улс нийтдээ 93.030 хавтгай дөрвөлжин км газар нутагтай бөгөөд Австри (366 км), Хорват (329 км), Румын (443 км), Серби ба Монтенегро, Словак, Словен, Украин улсуудтай хил залгадаг манайтай адил далайд гарцгүй улсын нэг юм.

Хамгийн сүүлийн мэдээгээр нийтдээ 10.006.835 хүн амтай бөгөөд хүн амын дундаж нас 38.7, дундаж наслалт 72.4. Хүн амын өсөлт - 0.26%, 2001 оны байдлаар 100 хүрэхгүй хүн ДОХ-ын халдвартай гэж бүртгэгдэж байжээ. Албан ёсны хэл нь унгар, хүн амын 67.5% нь католик, 20 % калвинст шашин шүтлэгтэй ажээ. Угсаатны бүтцийн хувьд 89.9% нь унгарчууд, 4% нь цыганууд, 2.6% герман, 2% серб болон цөөн тооны словак, румынчууд эзэлдэг ажээ.

Засаг захиргаа. Улсын нэр Унгар улс, унгар хэлээр Magyar Koztarsasag гэдэг, нийслэл нь эртний түүхт Будапешт хот. Парламентийн ардчилалсан засаглалтай, засаг захиргааны үндсэн 19 нэгжтэй. 1001 онд Нэгдүгээр Стефан хаан анх байгуулсан гэж үздэг бөгөөд жил бүрийн 8 дугаар сарын 1-нийг Ариун Стефаний өдөр буюу тусгаар тогтнолын өдөр гэж тэмдэглэдэг ажээ. Анх 1949 онд Үндсэн хуулий батласнаас хойш 1989 онд шинэчлэн мөрдөж эхэлжээ.

Эдийн засаг. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж эхлэх үед тэдний нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ нь тухайн үеийн Европын 4 том улсуудын талтай тэнцэх хэмжээнд байжээ. Өнөөдөр Унгар орон эдийн засгаа тогтвортой хөгжүүлж чадсанаар 2004 оны 5 сард Европын холбооны гишүүн болжээ. Тиймдээ ч өнөөдөр ДНБ-ний 80%-ийг хувийн сектор бүрдүүлдэг ажээ. Гадны хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих бодлогыг тууштай баримтлаж чадсанаар 1989 оноос хойш нийтдээ 23 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Манай 2 орны худалдааны эргэлт 2003 онд 3.8 сая ам.долларт хүрсэн байна. Эдийн засгийн шинэчлэлийн үр дүнд 1998 онд 14% байсан ханш уналтыг 2004 онд 7% болгож чадсан байна. Эдийн засгийн хамгийн томоохон түнш, хамтрагч нь Герман улс бөгөөд нийт экспортын 34.1%, импортын 24.5% нь уг улсад оногддог ажээ. 2003 онд ажилгүйдлийн төвшин 5.9%-тай гарсан байна. Мөнгөний нэгж нь forint (HUF) бөгөөд 2004 онд нэг ам.доллар 204.3 форинттой тэнцэж байгаа нь өмнөх жилүүдтэй харьцуулахад нэлээд тогтвортой, ханш нь өссөн үзүүлэлт юм.

2002 оны байдлаар 1.6 сая интернэт хэрэглэгчтэй байсан бөгөөд унгарын интернэт код нь .hu юм.

ПОЛЬШ

Польш нь Х зууны дунд үед бүрэлдэн бий болсон эртний үндэстний нэг гэж үздэг ажээ. Хөгжлийн алтан үе нь ХҮI зуун гэж тооцогддог бөгөөд удалгүй дотоодын зөрчил тэмцлээс шалтгаалан улс орны хүч чадал нь доройтон буурсан юм. 1772 болон 1795 оны Орос, Прусс, Австрийн хооронд байгуулсан хэлэлцээрээр Польшийг хэсэгчлэн хуваан захирч байжээ. Олон жилийн дараа 1918 онд өөрийн тусгаар тогтнолоо эргүүлэн олж авсан бөгөөд гэвч дэлхийн хоёрдугаар дайны үед Герман, ЗХУ-д эзлэгдэж байжээ. Дайны дараа Зөвлөлтийн дагуул орон болсон хэдий ч засаглалын хувьд хэт хуулбарлан дууриалгүй тодорхой хэмжээнд зөв бодлого явуулж чадаж байлаа. 1980 онд эхэлсэн хөдөлмөрчдийн үймээнээр бий болсон бие даасан үйлдвэрчний эвлэлийн байгууллага болох “Солидатор”-аар удирдуулсан шинэчлэл 1990-ээд онд эдийн засгийн шилжилтийн үед хүнд үеийг туулсан бөгөөд Төв Европын хамгийн ээдрээтэй орны нэгд тооцогдож байсан тухайн үед ДНБ-ний өсөлт болон ажилгүйдлийн төвшнөөр хамгийн өндөрт тооцогдож байлаа. 1999 онд НАТО, 2004 онд Европын Холбооны гишүүн болжээ.

Газар зүйн байрлал. Төв Европт, Германы зүүн хэсэгт орших энэ орон 312.6 мянган хавтгай дөрвөлжин нутаг дэвсгэртэй бөгөөд Беларусь, Чех, Герман, Литви, ОХУ-ын Калининград муж, Словак, Украин зэрэг оронтой нийтдээ 2788 км газраар хиллэдэг ажээ.

Хүн ам. 2004 оны 7 сард 38.6 сая хүн амтай энэ орны хүн амын дундаж нас 38.2, дундаж наслалт 74 бөгөөд өнөөдрийн байдлаар хүн амын өсөлт 0.02 % болжээ. Албан ёсны хэл нь польш, хүн амын 96.7% нь польш, 0.4% нь герман, үлдсэн нь беларусь, украин зэрэг үндэстнүүд эзэлдэг бол хүн амын 95% нь Ромын католик, цөөн хэсэг нь зүүний ортодокс, протестантууд байдаг байна. 2003 онд 14 мянга орчим хүн ДОХ-ын халдвар авсан бөгөөд тэдний 100 орчим нь нас барсан байна.

Засаг захиргаа: Нийслэл нь Варшав хот. 16 мужаас бүрэлдэх энэ орон бүгд найрамдах засаглалтай. 1918 оны 11 сарын 11-нд тусгаар тогтносон гэж үздэг бөгөөд 5 дугаар сарын 3-ныг Үндсэн хуулийн өдөр буюу баярын өдөр гэж тэмдэглэдэг одоогийн шинэ Үндсэн хуулиа 1997 оны 10 сараас эхлэн мөрдөж иржээ.

Эдийн засаг: 2003 оны байдлаар ДНБ 427.1 тэрбум ам.доллар болсон бөгөөд нэг хүнд ногдох хэмжээ нь 11.100 ам.долларт хүрчээ. Үүнээс 3.1% нь газар тариалан, 31% нь аж үйлдвэр, үлдсэн 65.9% нь үйлчилгээний салбарт оногдож байна. Хүн амын 18.4% нь амьдралын баталгаажих төвшнөөс доогуур амьдралтай ба ажилгүйдлийн төвшин 20%-д хүрсэн ажээ. Мөнгөний ханш уналт 2003 онд 0.7% гарчээ. 2003 онд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний өсөлт 8.6% болсноос ХАА-н голлох бүтээгдэхүүнд төмс, жимс ногоо, улаан буудай, гахай, шувууны аж ахуйн

бүтээгдэхүүн голлодог бол аж үйлдвэрийн бүтээгдэхүүнээс төмөрлөгийн үйлдвэрлэл, нүүрс, химийн үйлдвэр, усан онгоц үйлдвэрлэл, шил шаазан, оёмол бүтээгдэхүүн голлодог ажээ. Мөн онд 57.6 тэрбум ам.долларын экспорт, 63.6 тэрбум ам.долларын бараа бүтээгдэхүүн импортлосноос гадаад худалдааны голлох түнш нь Герман, Итали, Франц, Британи зэрэг орнууд болдог байна. Манай 2 орны худалдааны эргэлт 2003 онд 8 сая ам.долларт хүрсэн байна. Мөнгөний нэгж нь злот бөгөөд (PLN) 1999-2003 онд нэг ам.доллартай 3.9-3.8 буюу нэлээд тогтмол ханштай байжээ. 2003 онд 8.9 сая интернэт хэрэглэгчтэй, 17.4 сая хүн гар утас хэрэглэдэг болжээ. Интернэтийн код нь .pl юм.

ЧЕХ

Дэлхийн нэгдүгээр дайны дараагаар Австри-Унгарын эзэнт гүрний бүрэлдэхүүнд багтаж байсан ойрын хэлхээ холбоотой Чех, Словак улсууд нь нэгдэж Чехословак улсыг байгуулж байжээ. Дэлхийн хоёрдугаар дайны дараа Чехословак нь Зөвлөлтийн холбоотон улс болон хувирсан байна. 1968 онд Варшавын гэрээний дагуу орж ирсэн цэргийн хүчний нөлөөгөөр улс орондоо Коммунист намын “хүнд чиглэсэн коммунизм” байгуулахаар зорьж байсан удирдлагуудын зорилт талаар болжээ. Энэ бүх хугацаанд Зөвлөлтийн эсрэг үзлийг олон удаа нухчин дарж байжээ. 1989 онд Зөвлөлт засаг задран унах үед Чехословак нь “Тансар хилэн хувьсгал”-ын үр дүнд өөрийн тусгаар тогтнолын эрх чөлөөг олж авчээ. 1993 оны нэгдүгээр сарын 1-нд Чех, Словак нь тусдаа бие даасан улс болон тусгаар тогтносон юм. Үүний дараагаар Чех нь 1999 онд НАТО, 2004 онд Европын холбооны гишүүн улс болжээ.

Газар зүйн байрлал: Төв Европт Германы зүүн өмнөт хэсэгт 78.866 хавтгай дарвөлжин газар нутагтай бөгөөд Австри, Герман, Польш, Словак улсуудтай 1.881 км урттай газар нутгаар хүрээлүүлэн оршдог манайтай нэгэн адил далайд гаршгүй орны нэг юм. Байгалийн голлох гамшигт үер усны аюул тооцогддог ажээ.

Хүн ам: 2005 оны байдлаар 10.2 сая хүн амтай бөгөөд дундаж нас 38.9, дундаж наслалт нь 76.2 байдаг бол хүн амын өсөлт нь - 0.05% болсон ажээ. 2001 онд 2.500 орчим хүн ДОХ-ын халдвар авснаар бүртгэгдэж байсан бол тэдний 10 орчим нь нас барсан гэсэн бүртгэлтэй байна.

Хүн амын угсаатан зүйн бүлэглэлийн хувьд дийлэнх буюу 81.2% нь чех, 13.2% нь морав, 3.1%-ийг нь словак болон польш, герман, силез, цыган, унгарчууд байдаг ажээ. Харин бусад улсаас ялгагдах нэг онцлог нь хүн амын 39.38% нь сүсэг бишрэлгүй гэж бүртгэгдсэн байхад 39.2% нь ромын католик, 4.6% нь протестант, 3% нь ортодокс бол үлдсэн 13% нь өөр шашин шүтдэг ажээ. Улсын албан ёсны хэл нь чех хэл.

Засаг захиргаа: Парламентын ардчилсан тогтолцоотой бүгд найрамдах засаглалтай ажээ. Улсын нийслэл нь “алтан” хэмээх тодотголтой Прага хот юм. Нийтдээ 13 бүс нутгаас бүрэлдэн тогтдог. 1918 оны 10 сарын 28-нд Чех улс байгуулагдсан өдөр хэмээн тэмдэглэн өнгөрүүлдэг ажээ. Шинэ үндсэн хуулиа 1993 оны 1 сарын нэгнээс мөрдөж байна.

Эдийн засаг: Чех нь Төв болон Дорнод Европын хуучин коммунист улсууд дотроо хамгийн тогтвортой, өндөр хөгжилтэй улсуудын нэгд зүй ёсоор ордог ажээ. 2000-2004 оны эдийн засгийн өсөлт тэр дундаа Европын холбоонд оруулсан экспортын худалдаа, гадаад дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ нь эрс нэмэгдсэн ажээ. Мөнгөний ханш уналтын хэмжээг бүрэн хяналтандаа авч тогтвортой барьдаг төдийгүй өмч хувьчлалын асуудлыг зоригтойгоор шийдэж байгаа бөгөөд энэ онд төрийн өмчит томоохон аж ахуйн нэг Чех цахилгаан холбоо компанийг хувьчлахаар болсон ажээ. 2004 оны байдлаар ДНБ-ний хэмжээ 172.2 тэрбум ам.доллар болж нэг хүнд ногдох хэмжээ нь 16.800 ам.долларт хүрчээ. Үүнээс салбарын хувьд 57.3% нь үйлчилгээний салбарт, 39.3% нь аж үйлдвэрийн салбарт оногддог ажээ. Мөн онд инфляц буюу мөнгөний ханш уналт нь 3.2% байсан бол ажилгүйдлийн төвшин 10.6%-д хүрсэн байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлт нь 4.7% хүрсэн ба ХАА-н гол бүтээгдэхүүн нь арвай, төмс хүнсний ногоо, гахайн аж ахуй байдаг бол аж үйлдвэрийн хувьд төмөрлөг боловсруулалт, шил шаазан, машин үйлдвэрлэл ордог байна. Манай 2 орны худалдааны эргэлт 2003 онд 5.9 сая ам.долларт хүрсэн байна.

Өнгөрсөн онд 66.51 тэрбум ам.долларын барааг Герман, Словак, Австри, Британи, Польш, Франц, Итали зэрэг оронд голлон гаргасан бол 68.19 тэрбум ам.долларын бараа бүтээгдэхүүнийг Герман, Итали, Хятад, Словак, Франц зэрэг орноос импортлон оруулж иржээ. Мөнгөний нэгж нь крон буюу CZK бөгөөд 2004 он байдлаар 1 ам.доллар 25.7 кронтой тэнцэж байгаа нь өмнөх 4 жилтэй харьцуулахад нэлээдгүй чангарсан үзүүлэлт ажээ.

Харилцаа холбоо: 2003 онд энэ оронд 9 сая гаруй гар утас хэрэглэгч бүртгэгдсэн байгаа нь маш өндөр үзүүлэлт бөгөөд 2.7 сая интернэт хэрэглэгчтэй ажээ. Интэрнэтийн олон улсын код нь .cz юм байна.